

# ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



70462854, 70462855



[zavkhan@burtgel.gov.mn](mailto:zavkhan@burtgel.gov.mn)



[Zavkhan.burtgel.gov.mn](http://Zavkhan.burtgel.gov.mn)



Завхан аймаг  
Улиастай хот Жинст  
баг явуугийн гудамж

**ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАНГИЙН АГУУЛГА**

1. Нэгжийн чиг үүрэг, бодлогын баримт бичгийн талаар
  - 1.1 Удирдлага зохион байгуулалт
  - 1.2 Хүний нөөцийн талаар
  - 1.3 Иргэний улсын бүртгэл
  - 1.4 Хуулийн этгээдийн улсын бүртгэл
  - 1.5 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
  - 1.6 Хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагаа
  - 1.7 Архивын үйл ажиллагаа
2. Төлөвлөгөө, үүрэг даалгаврын хэрэгжилт
  - 2.1 Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас өгөгдсөн үүрэг, даалгавар, тушаалын хэрэгжилт
3. Санхүүгийн үйл ажиллагаа
  - 3.1 Санхүү, үнэт цаасны тооцоо, тайлан мэдээ
4. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛГИЙН ТАЛААР
  - 4.1 Ил тод байдал
  - 4.2 Шилэн данс
5. Бусад
  - 5.1 Бусад байгууллагатай хамтран ажилласан тухай, Идэвхи санаачлага шинэлэг ажил

## НЭГ: НЭГЖИЙН ЧИГ ҮҮРЭГ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЛААР

### 1.1 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2024 онд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтын дагуу Монгол улсын үндсэн хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмуудыг хэрэгжүүлэн иргэний бүртгэлийн чиглэлээр, 13339 иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 5760 иргэн, хуулийн этгээдийн чиглэлээр 1692 иргэн нийт 20791 иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай чанартай хүргэн ажиллалаа.

### 1.2 ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн А/428 тоот тушаалаар батлагдсан орон тооны дагуу 2024 онд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 4, иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 3, архивч 2, ахлах нягтлан бодогч 1, нярав, бичиг хэргийн ажилтан 1, мэдээллийн технологийн ажилтан 1, Гэрээт албан хаагч 5, сумдын 25 улсын бүртгэгч нийт 46 албан хаагчтайгаар улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна.

2024 онд сул орон тооны зарыг олон нийтэд зарлах, цахим болон мэдээллийн самбарт байршуулсан ба нийт 4 орон тооны зарыг зарлаж улсын бүртгэгч 4, хуулийн дагуу шинээр томилогдон ажиллаж байна.



### 1.3 ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний улсын бүртгэлийн тасаг нь 27 улсын бүртгэгч, 1 ахлах бүртгэгчтэйгээр иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг 2024 онд 11861 иргэнд үзүүлсэн байна. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 11861 бүртгэлийн 16595 нотлох баримтыг цахимжуулж, хянан мэдээллийн санд баталгаажуулсан байна. Тоон гарын үсгийг 2024 оны 11 сарын байдлаар өссөн дүнгээр 13339 иргэдэд олгосон.


Мөн сумын улсын бүртгэгч нарыг мэдээ мэдээллээр тогтмол ханган 2024 онд ажиллах ажил үүргийн хуваарь болон цахимжуулах дарааллыг гарган хүргүүлж ажилласан.

Улсын бүртгэлийн мэдээллийн санд регистрийн дугаар буруу, овог, нэр, үсгийн зөрүүтэй иргэдийн зөрчлийг тухай бүр арилгаж хяналтын улсын байцаагчийн 76 дүгнэлт гаргуулж ИУБ-11,-ИУБ-15, ИУБ-16 маягтыг тус тус нөхөн бичиж мэдээллийн санд оруулсан. Мэдээллийн санд үсгийн алдаатай болон мэдээлэл буруу орсон 145 иргэний мэдээллийг нэгдсэн дүгнэлтүүдээр засварласан.


2024 оны Иргэний улсын бүртгэлийг графикаар харуулбал



## Үрчлэлт, эцэг тогтоолт, овог нэр өөрчлөлт



## Шилжилт хөдөлгөөн



### Олгосон лавлагааны тоо

Иргэнд 2627 лавлагаа албан хэрэгцээнд 1484, вэб 1, албан тоотоор 525 лавлагааг өгч ажилласан байна. Нийт иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн албан бичиг: 2024 оны 11-р сарын байдлаар нийт 21 албан бичгийг ИУБГ-т хүргүүлсэн.

### ҮНДЭСНИЙ ЭНГИЙН ГАДААД ПАСПОРТ ОЛГОЛТЫН ТАЛААР

2024 онд олгосон гадаад паспортын үйлчилгээг харьцуулсан үзүүлэлт

Д/д	Он	Гадаад паспорт шинэ	Хил зорчих олон удаагийн үнэмлэх	Хил зорчих нэг удаагийн үнэмлэх
1	2023 он	2293	0	213
2	2024-10	2024	0	681

### 1.4 ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ

Тайлант хугацаанд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ажил, үйлчилгээг, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийг бүрэн хэрэгжүүлж, 2024 оны 11-р сарын байдлаар нийт 1692 иргэн, хуулийн этгээдэд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН-ЗАВХАН

Д/д	Хуулийн этгээдийн бүртгэлийн төрөл	2023 он	2024 он
1	Хуулийн этгээдийн нэр баталгаажуулалт	162	676
2	Шинээр үүсгэн байгуулсан хуулийн этгээд	87	578
3	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	65	78
4	Төрийн бус байгууллага /НҮТББ, ГҮТББ/	9	24
5	Нөхөрлөл	4	4
6	Хоршоо	5	465
7	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	2	0
8	Сан	0	2
9	Төрийн байгууллага, албан газар	0	1
10	Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт	126	191
10	Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа олгосон	95	247
11	Хуулийн этгээд татан буулгасан бүртгэл	6	0
	<b>Нийт</b>	<b>561</b>	<b>1692</b>

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.3 т заасаны дагуу аймагт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн салбарыг бүртгэсэн.


Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/216 тоот тушаалаар батлагдсан “Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”-ын дагуу Хуулийн этгээдийн тамга, тэмдэгийн хяналтын хуудас 183 олгож, хуулийн этгээдийн 35 тамга, тэмдгийг хураан авч хүчингүй болгосон.

Тайлангийн хугацаанд шинээр байгуулагдсан 578 хуулийн этгээдийн, 194 хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн, лавлагааны эх нотлох баримт бичиг хураан авсан тамга тэмдгийг журмын дагуу архивт хүлээлгэн өгч, цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна.

### 1.5. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХҮРЭЭНД

Тайлант хугацаанд нийт 5760 мэдүүлэг хүлээн авч эд хөрөнгө өмчлөх эрх түүнтэй холбоотой эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журам, чиглэлд заасны дагуу эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын 5760 бүртгэлийг хийсэн. Тосонцэнгэл, Баянтэс, Сонгино, Цагаанхайрхан, Их-Уул, Нөмрөг, Тэмлэн, Цагаанулуут, Сантмаргац, Тэс сумдад 1658 бүртгэл буюу нийт бүртгэлийн 28,7 хувийг эзэлж байна.


**Нийт бүртгэлийн тоог өмнөх онуудтай харьцуулвал:**




2.Нийт бүртгэлийг төрлөөр нь өмнөх онуудтай харьцуулвал:



### Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл




### Бусад бүртгэл








### Барьцааны бүртгэл



### Өмчлөх эрх шилжих бүртгэл




- Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл
- Шинээр баригдсан орон сууцны анхны бүртгэл
- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл



Тайлант хугацаанд нийт 1579 гэрчилгээ бичиж олгосноос 864 үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн, 715 газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг тус тус бичигдсэн байна.

**Бүртгэж олгосон гэрчилгээ:**



Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолын дагуу байгууллагад үйлчилгээний хураамжаас 65.971.000 сая төгрөг орон нутгийн төсөвд тэмдэгтийн хураамжаас 2.826.976 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны албан татвараас 358.594.849 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Нийт мэдүүлгийг цахим мэдээлийн сан болох Electronic Property Registration System

(ePRS)-т 5760 бүртгэлийг шивж оруулсан бөгөөд газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 367 хувийн хэрэг, газар өмчлөх эрхийн 248 хувийн хэрэг шинээр нээж, 18 хувийн хэрэг хааж, 5145 мэдүүлгийн бүртгэлийн үйлчилгээний баяжилтыг бүртгэж ажилласан.

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу 115 лавлагаа мөн хууль хяналтын байгууллагаас ирсэн 90 тоотын 186 иргэний лавлагаа мэдээллийг холбогдох хууль журмын дагуу гаргасан. Монголын ипотекийн корпорацийн барьцаа хөрөнгө чөлөөлөх тухай 9, ХААН, Хас, Төрийн банкны нийт 24 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг эрхийн улсыг бүртгэлд бүртгэсэн. Хяналтын улсын байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1500 дугаартай дүгнэлтийг үндэслэн 225 хувийн хэрэгт завсар өөрчлөлт хийсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журам, чиглэлд заасны дагуу эд хөрөнгийн бүртгэлийн тоо мэдээг заасан маягт загварын дагуу 11 удаа, Үнэт цаасны мэдээг 11 удаа гарган холбогдох газарт нь хүргүүлсэн.

## 1.5 ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 онд Иргэний улсын бүртгэлийн зөрчил арилгах хяналтын улсын байцаагчийн 36 дүгнэлт гарган, 3654 бүртгэлд хяналт тавьж, 29 зөрчил илрүүлэн 18 зөрчлийг шалгалтын явцад шийдвэрлэсэн. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 108 бүртгэлд хяналт тавин ажиллалаа. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн зөрчлийг арилгах хяналтын улсын байцаагчийн 42 дүгнэлт гарган, 1564 бүртгэлд хяналт тавьж, 4 зөрчлийг илрүүлэн зөрчлийг шалгалтын явцад шийдвэрлэсэн. Мөн тайлант хугацаанд 292 бүртгэл хүчингүй болгон ажиллалаа.

Жилийн эцсийн байдлаар 881 бүртгэлд цахимаар хяналт тавин, зөрчилтэй 3 бүртгэлийн зөрчлийг арилгах хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарган ажиллалаа.

2024 онд Иргэний улсын бүртгэлтэй холбоотой 24, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 22, зөрчлийн талаарх 226 гомдол мэдээлэлийг нийт 272 өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шалган шийдвэрлэсэн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.20-д заасан зөрчилд улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч шалган шийдвэрлэхээр заасны дагуу 233 иргэнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 4.4 сая төгрөгийн торгох шийтгэл оногдуулан ажилласан байна.

Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн бүртгэлийг 11 удаа, зөрчил шалган шийдвэрлэсэн материалыг 5 удаа аймгийн Прокурорын газарт хянуулан ажиллаж, аймгийн Прокурорын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу 2024 оны хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн материалыг 5 удаа шалгуулан ажиллаж байна.

Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу шилжилт хөдөлгөөний 1606 бүртгэлд хяналт шалгалт хийж дүнг илтгэх хуудсаар Хэлтсийн даргад танилцуулан УБЕГ-ын Хяналт шалгалтын газарт хүргүүлэн илэрсэн 20 зөрчлийг шийдвэрлэн ажиллалаа.

Бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт тавьсан бүртгэлийн тоо өмнөх оноос 77.7 хувиар өсч, илрүүлсэн зөрчлийн тоо 18,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### 1.6 АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэний улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн баримтын архивын үйл ажиллагааг сайжруулах, хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, архивын баримт, хадгаламжийн нэгжийг эмх цэгцтэй байлгах, иргэд, аж ахуй нэгж, байгуулагад үзүүлэх архивын үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна.



Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт Алдархаан сумын газраас бусад үл хөдлөх хөрөнгийн хувийн хэргийн 600, Улиастай сумын 3200 хувийн хэргийн цэнхэр хавтасыг стандартад нийцсэн цаасан хайрцагт хийж байршуулан ажиллалаа

. Тайлант хугацаанд сүлжээ тасарсан үед Улсын бүртгэгчдэд 124 хувийн хэргийг татан ажилласан байна. УБЕГ-Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газраас онлайнаар эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасагт шалгалт хийж зөрчлийн тэмдэглэл ирүүлсэн 55 хувийн хэргийг ахлах бүртгэгчид архиваас татаж зөрчлийг арилгуулах ажлыг хийсэн. Мөн Хяналтын байцаагч сар бүрийн эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээнээс нийт 60 хувийн хэрэгт хяналт тавсанг хувийн хэргийг татан өгч, буцаан авч байршуулан ажиллаа.

Тайлант хугацаанд газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 367, газрын 248 хувийн хэрэг шинээр нээгдсэнг бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хөтлөн архивт байршуулан ажиллалаа.

2024 оны 11 сарын байдлаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт 3285, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт 16933 Иргэний улсын бүртгэлийн архивт 73000 хувийн хэрэг, 920 бүртгэлийн дэвтэр тус тус хадгалагдаж байна.

Иргэний улсын бүртгэлийн архивын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр шинээр

бүртгэл хийгдсэн ИУБ11-804, ИУБ12-14, ИУБ13-33, ИУБ14-34, ИУБ15-176, ИУБ16-25, ИУБ18-329, ИУБ31-3050 нийт 4465 ширхэг ИУБ маягтыг хүлээн авч хувийн хэрэгт байршуулан баяжилт хийсэн.

Шинээр 16 насанд хүрч иргэний үнэмлэх авсан 484 иргэний ХААТР-11 маягтыг хүүхдийн сангаас түүвэрлэн авч ИУБ-31 маягтын хамт хувийн хэргийн санд байршуулан баяжилт хийж ажилласан.

161 иргэний ИУБ-18 маягтыг тухайн хувийн хэргийн хамт түүвэрлэн нас баралтын санд байршуулсан. Шилжилт хөдөлгөөний дагуу гадна аймаг нийслэлрүү шилжин явсан 185 иргэний хувийн хэргийг архивын сангаас түүвэрлэн жагсаалт үйлдэн холбогдох аймаг, нийслэлд хүргүүлсэн. Гадна аймаг, нийслэлээс нэхэмжилсэн 815 иргэний хувийн хэргийг архивын санд байршуулан баяжилт хийн ажилласан.

## ХОЁР: ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН ХЭРЭГЖИЛТ

### 2.1 УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ, ДААЛГАВАР, ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТ

2024 онд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 20 удаагийн шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтүүдийг гарган холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын Улсын бүртгэгч томилож, чөлөөлсөн 4 тушаал, Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай 1, Тушаалд өөрчлөлт оруулах тухай 2, Урамшуулал олгох тухай 1, УБЕГ даргын “Эрхийн улсын бүртгэл хаах” 2 тушаал, Иргэн, ХЭЭХЭУБГ-талаар 16-н чиглэл, тайлан ирүүлэх тухай, хугацаатай үүрэг даалгаварыг цаг тухай бүрт нь Улсын бүртгэгч нарт бүрэн танилцуулан хүргүүлэн сумдын бүртгэгч нарт онлайнаар 25 удаа заавар зөвлөгөө өгч, эдгээр чиглэл зөвлөмжийг бүртгэл хөтлөхдөө мөрдлөгө болгон ажилласан байна.


## ГУРАВ: САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 3.1 САНХҮҮ, ҮНЭТ ЦААСНЫ ТООЦОО, ТАЙЛАН МЭДЭЭ

**Төсвийн зарцуулалт:** Улсын төсвөөс 1837.5 сая төгрөгийн санхүүжилт авч Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд 1502.8 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 65.4 сая, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой урамшуулал тусламж дэмжлэгт 240.8 сая, бусад бараа үйлчилгээний зардалд 28.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтэст төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, тайланг сар бүрийн 2-ны дотор 5 удаа, улирлын тайлангуудыг холбогдох тодруулгын хамт хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан.

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Төрийн аудитаар хянуулж “Зөрчилгүй” дүгнэлтээр үнэлэгдсэн болно.

**Үйлчилгээний хураамж, үйл ажиллагааны орлого:** 2024 оны Улсын бүртгэлийн үйлчилгээний орлогоос 120.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 163.4 сая төгрөгийг Улсын төсвийн 170000075756 тоот дансаар дамжуулан төвлөрүүлж 36.0 хувиар давуулан биелүүлж ажиллалаа.



### Бараа материал, үндсэн хөрөнгө:

Иргэний улсын бүртгэлийн 21 төрөл, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн 3 төрөл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 3 нийт 27 төрлийн үнэт цаас ашиглагдаж байгааг Улсын бүртгэлийн ерөнхий газраас хөрөнгийн санхүүжилтээр 5 удаагийн татан авалт хийж нөөцийг бүрэн ханган ажиллаж байна. Хэлтэс шинэ байранд орсонтой холбоотой цэвэрлэгээ, засвар үйлчилгээний зардал нэмэгдсэн боловч батлагдсан төсөвтөө багтаан зарцуулалт хийж ямар нэгэн өр, авлагагүй ажилласан.

Тайлант хугацаанд сумдын Улсын бүртгэгчид болон албан хаагчидад олгосон үнэт цаас, хаатр маягт, бичиг хэргийн материалуудыг зохих журмын дагуу шаардах хуудас бичүүлж, агуулахын бүртгэлийн дэвтэр хөтөлж, өгсөн үнэт цаасны хатуу дугаарыг онлайн програмд хуваарилан ажиллаж байна.

## ДӨРӨВ :МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТАЛААР

Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээллийн технологийн ажилтан нь “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”, монгол улсын засгийн газраас баталсан “Мэдээлэл, сүлжээний аюулгүй байдлыг хангах” журмыг удирдлага болгон дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

### 4.1 МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР

Мэдээлэл технологийн чиглэлээр 2024 оны жилийн эцсийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Иргэдэд үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт болон шинэчлэгдсэн баримт бичгүүдийг цахимд ойлгогдохуйц байдлаар байршуулсан.

**Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:** үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээний төрөл тус бүрээр бүрдүүлэх материалын жагсаалтыг хэвлэж,

иргэдэд олгох ажлыг зохион байгуулж хэлтсийн web сайтад 18 төрлийн үйлчилгээг авахад шаардагдах бүрдүүлбэрийг улсын бүртгэлийн сайтын линк холбоосыг өөрийн цахим хуудас болох [www.zavkhan.burtgel.gov.mn](http://www.zavkhan.burtgel.gov.mn) байршуулснаар улсын бүртгэлд бүртгүүлэх бүрдүүлбэрүүдийг хэлтсийн байранд ирж үйлчилгээний ажилтнаас зөвлөгөө авах шаардлагагүй QR үүсгэж иргэн гар утаснаас бүрдүүлбэрээ цахимаар авах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

2024 оны Монгол Улсын Их хурлын сонгууль, АНСДИТХурлын сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтны програмын сургалтанд хэсэг тус бүрийн лавлагаа тусгах ажлыг хийсэн байна.

**Эд хөрөнгийн эрх,хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:** үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээний төрөл тус бүрээр бүрдүүлэх материалын жагсаалтыг хэвлэж, иргэдэд олгох ажлыг зохион байгуулсан. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь өдөр тутамд ашиглагддаг 12 үйлчилгээний төрлийн бүрдүүлбэрийн самбар хэвлэж, үйлчилгээний зааланд байршуулсан. Түүнчлэн хэлтсийн web сайтад 16 төрлийн үйлчилгээг авахад шаардагдах бүрдүүлбэрийг байршуулсан нь хэлтсийн байранд ирж үйлчилгээний ажилтнаас зөвлөгөө авах шаардлагагүй QR уншуулан цахимаар авах боломжтой байна. Үйлчилгээний зааланд байрших улсын бүртгэлийн үйл ажиллагааны ил тод байдлын самбарт үйл ажиллагаагаа сурталчлан ажиллав.

Хэлтсийн болон сумдын улсын бүртгэгчдийн бүртгэлийн онлайн сүлжээнд хандаж програмд нэвтрэх эрхүүдийг дотоод журмад заасан хугацаанд солиулах, тэдгээрийн ашигладаг тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарах бүрт шаардлагатай арга хэмжээг авч програмын болон тоног төхөөрөмжийн тохиргоог хийн системийн лог бүртгэл хийх боломжоор ханган хяналт тавин ажиллаж байна. Иргэний бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн бүртгэл, Хуулийн этгээдийн бүртгэл зэрэг бүртгэлүүдийн улсын бүртгэгчдийн онлайн програмд ашиглаж байгаа програм хангамжуудын шинэчлэл/update/-ийг тухай бүр шинэчлэж хэвийн ажиллах боломж бололцоог цаг алдалгүй түргэн шуурхай хийж гүйцэтгэж байна. Үүнд иргэний 7 төрлийн бүртгэлийн, [www.civil.mn](http://www.civil.mn) програмын шинэчлэл сайжруулалт, Цахим гарын үсэг олголтын PKI, [www.sign.mn](http://www.sign.mn) програмууд, ЭХЭУБ-н [www.eprs.mn](http://www.eprs.mn) онлайн програмын шинэчлэл сайжруулалт, хуулийн этгээдийн [www.ers.gasr.mn](http://www.ers.gasr.mn), хяналт шалгалтын програм [www.app-audit.gasr.mn](http://www.app-audit.gasr.mn), гадаад паспортын зураг засварын програм, иргэний үнэмлэхний зураг засварын Албан хэрэг хөтлөлтийн [www.intranet.mojha.mn](http://www.intranet.mojha.mn), г.м бүртгэлийн бүх програмуудын шинэчлэл тохиргоог хийж төрийн бүртгэлийн үйлчилгээний тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна.

Цахим хуудаст байгууллагын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг цаг тухай бүрт нь байршуулсан ба бүтэн жилийн байдлаар цаг үе, үйл явдлын талаарх мэдээ 18, иргэд, аж ахуй нэгжүүдэд заавар зөвлөгөө өгсөн талаар бичлэг 17, иргэд аж ахуй нэгжүүдэд заавар зөвлөгөө өгсөн мэдээлэл 35-г байгууллагын албан ёсны цахим хуудас болох [www.Zavkhan.burtgel.gov.mn](http://www.Zavkhan.burtgel.gov.mn) хаягт 41 мэдээ мэдээлэл мөн [Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс facebook page-д](#) 93, мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн КИОСК машиныг 2024 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн үйлчилгээний заалны үүдний коридорт байршуулан 24/7 бүртгэлийн үйлчилгээг 24 цагаар олгох боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Иргэд шаардлагатай улсын бүртгэлийн лавлагаа үйлчилгээг авахаас гадна бүртгэлийн үйлчилгээний төлбөр тооцоог хийх пос машиныг холбон ажиллаж байна. Улсын бүртгэлийн 24/7 цахим үйлчилгээ талаарх мэдээлийг өөрийн цахим хаяг <https://zavkhan.burtgel.gov.mn/> фэйсбүүк пэйж хуудаст сурталчлан видео контентыг хийн иргэдэд хүргэж тус видео контент нь 10237 хүний хандалт авсан байна. Мөн хагас жилийн байдлаар Дөт Киоск машинаас 2024 1 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 15-ны хооронд улсын бүртгэлийн лавлагаа 5326 тоон гарын үсэг 2160 төлбөр тооцоо 123 тус тус авагдсан байна.

Хэлтсийн албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжүүдийг эвдрэл гэмтэл гарсан үед цаг алдалгүй тухай бүрт нь засварлаж хэвийн ажиллагаанд ажиллуулж байна.

Байгууллагын дотоод сүлжээний ажиллах хэвийн байдлыг бүрдүүлэн сүлжээнд алдаа гарах, тасрах гэх мэт техникийн саатлуудыг тухай бүрт нь холбогдох арга хэмжээг аван ажиллаж байна.

2024 оны бүтэн жилээр Улсын бүртгэлийн ерөнхий газраас цахим видео хурал, болон сургалтууд 26 удаа хийгдэж цахим хурлыг тухай бүрт нь холбон техник төхөөрөмжийг хэвийн ажиллуулсан байна. Завхан аймагийн Улсын бүртгэлийн хэлтэс нь сумын улсын бүртгэгч нартайгаа цахим видео хурал болон сургалтыг 15 холбон ажилласан.

Байгууллагын сүлжээний аюулгүй байдал, гадны халдлага, мэдээлэл алдагдхаас сэргийлэн арга хэмжээ авч ажиллан Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн заавар зөвлөмжийн дагуу сүлжээний хамгаалалтыг сайжруулж тохиргоог хийнажиллаж байна.

## 4.2 ИЛ ТОД БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Нийтийн мэдээллийн ил тод байдлыг тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуулиудын хүрээнд байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газар 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж, авлигатай тэмцэх таван Ш буюу Шүгэл, Шүүр, Шувуу, Шилжүүлэн авах болон Шил ажиллагааг хэрэгжүүлж буй. Иргэдийн мэдээлэл хайх, мэдээлэл хүлээн авах эрхийг хангах, ажлын хүрээнд <https://frontoffice-dev.shilen.gov.mn/index> 2 дугаар улирлаар 5 чиглэлийн 87 мэдээллийг байршуулсан ажилласан нь 80.85% үнэлэгдэж 4-р улирлаар тайлангаа 12 дугаар сарын 01-ны дотор илгээхээр ажиллаж байна.



Хэлтсийн мэдээллийн ил тод байдлын самбарт Улсын бүртгэлийн хууль тогтоомж тушаал шийдвэр төсөв санхүү, статистик тоо мэдээ, бараа материал худалдан авалтын мэдээллийг сар бүр байршуулдаг мөн хэлтсийн вэб сайт шилэн данстай холбон мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

Байгууллагын хийж гүйцэтгэсэн ажил, иргэдэд мэдээлэх шаардлагатай мэдээг цаг тухай бүрт нь байршуулсан ба цахим хуудас болон [facebook](#) хуудсанд бүтэн жилийн байдлаар 93 мэдээ мэдээлэл тавигдсан байна.

Өргөдөл, гомдол хүлээн авах хариуцсан албан хаагчийн албан тушаал, овог нэр, харилцах утасны дугаар тодорхой бичиж цахимд байршуулсан.

Сул орон тооны зарыг нийтэд зарлах, цахим болон мэдээллийн самбарт иргэдэд харагдахуйц байршуулсан ба нийт 4 тооны зарыг байршуулан ажиллаж байна.

### 4.3 ШИЛЭН ДАНС

Хэлтсийн мэдээллийн ил тод байдлын самбарт Улсын бүртгэлийн хууль тогтоомж тушаал шийдвэр төсөв санхүү, статистик тоо мэдээ, бараа материал худалдан авалтын мэдээллийг сар бүр байршуулдаг мөн хэлтсийн вэб сайт шилэн данстай холбон мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн мэдээллийг сар бүрийн 8-ны өдрийн дотор 29 үзүүлэлтээр 164 мэдээллийг бүрэн байршуулж, улирлын тайланг хугацаанд нь илгээн ажилласан

### ТАВ: БУСАД

#### 5.1 БУСАД БАЙГУУЛЛАГТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ТУХАЙ, ИДЭВХИ САНААЧЛАГА ШИНЭЛЭГ АЖИЛ

1. Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 102 жилийн ойг тохиолдуулан Хууль зүйн яамны харьяа тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд жил бүр уламжлан болгон зохион байгуулагддаг спортын 8 төрлөөр цогцолбор тэмцээн зохион байгуулагдлаж эмэгтэй гар бөмбөгийн тэмцээн тэргүүн байр эзэлсэн.

## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН-ЗАВХАН



2. Дөрвөн оноо өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран ажилтан албан хаагчдаа Танита аппаратаар 7 үзүүлэлт Оношилгоо шинжилгээд хамруулан зөвлөгөө мэдээлэл авлаа.



3. Аймгийн биеийн тамир спортын газраас зохион байгуулсан бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох сорилд хэлтсийн 8 албан хаагч хамрагдав.



4. Эрүүл мэндийн газрын сургалт хариуцсан мэргэжилтэн н.Отгонсүрэн Гэр бүлийн эрүүл мэнд ба Эрүүл амьдралын дадал сургалтыг зохион байгуулсан.



5. Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран засан хүмүүжигч нарт Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч Тоон гарын үсэг олгож ажиллалаа.



6. Аймгийн засаг даргын тамгын газар Төрийн захиргаа удирдлагын хэлтэстэй хамтран Төрийн албаны ерөнхий шалгалтыг 4 удаа зохион байгуулсан байна.



7. “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийн хүрээнд улсын бүртгэлийн албан хаагчид гамшгийн аюулын дохиогоор ажиллах дадлага, сургуулилтад амжилттай хамрагдлаа. Засгийн газрын 2011 оны 339-р тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”-д зааснаар жил бүрийн 03 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Пүрэв гарагийн 16.00 цагт гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтыг улс орон даяар зохион байгуулдаг. 2024.03.28-ны 16:00 цагаас орон даяар Гамшгийн үеийн зарлан мэдээллийн дуут дохиогоор тус хэлтсийн хамт олон оролцсон.



“Цахимд хэвшье” үндэсний хэмжээнд өрнөж буй аяны хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, “И-Монгол академи” УТҮГ, “Үндэсний дата төв” УТҮГ, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбоо ТББ гишүүн 22 байгууллагын хамтарсан 57 хүний Бүрэлдэхүүнтэй мэргэжлийн баг баруун бүсийн 5 дахь аймаг болох Завхан аймагт 2024 оны 04 сарын 12-нд зохион байгуулсан.



## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН-ЗАВХАН

8. Бүсчилсэн хөгжил-Хариуцлагатай газрын харилцаа” жилийн хүрээнд Газар, геодези, зураг зүйн чиглэлээр хэрэгжиж буй хууль тогтоомж, цахим систем, үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлах, газрын зөрчил, маргааныг шийдвэрлэх, төрийн хяналт шалгалтыг иргэд, нийтийн оролцоотой, үр дүнтэй зохион байгуулах зорилго бүхий “Хариуцлагатай газрын харилцаа” аяныг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 30-ний өдрийг хүртэл улсын хэмжээнд зохион байгуулахад хамтран ажилласан.



9. Монголын хуульчийн холбооноос жил бүр зохион байгуулдаг “Хуульчийн Про Боно өдөр-2024” өдөрлөг 2024 оны 05 сарын 01-ий өдөр зохион байгуулагдаж хамтран оролцсон.

Энэхүү өдөрлөгөөр

- Иргэний улсын бүртгэл
- Хуулийн этгээдийн улсын бүртгэл
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр иргэн аж, ахуйн нэгжид зөөврийн тоног төхөөрөмж ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн заавар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.



11. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ БАГТ" арга хэмжээг 2024 оны 05 сарын 07-09-ны өдрүүдэд Завхан аймгийн Засаг даргын тамгын газраас Улиастай суманд зохион байгуулахад хамтран ажилласан.

Тус арга хэмжээнд Улсын бүртгэлийн хэлтэсээс:

- ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ
- ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ
- ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ-ийн талаар иргэдэд зөвөлгөө мэдээлэл хүргэж , санал хүсэлтийг хүлээн авч хамтран оролцсон.



12. Завхан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Тогтвортой амьдрал-Амгалан гэр бүл” арга хэмжээний хүрээнд “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран “Гэр бүлийн үнэ цэнэ, хосуудын харилцаа” сургалтыг зохион байгуулж залуу хосуудын “ГЭРЛЭЛТИЙН БАТЛАХ ГАРДУУЛАХ ЁСЛОЛ”-ыг 05 дугаар сарын 17-ны өдөр 3 дахь удаагаа хамтран зохион байгууллаа.



13. “Хаврын их цэвэрлэгээ” Улиастай сумын засаг даргын 2024 оны 05 сарын 22-ны өдрийн 1/188 тоот захирамжын дагуу зохион байгуулж өөрийн эзэмшил болон нийтийн хувиарт газрынхаа хог хаягдал цас мөсийг тухай бүрд нь цэвэрлэн ажиллаж байна. Их цэвэрлэгээнд хэлтсийн бүх албан хаагчид хамрагдаж өөрсдийн автомашинаар ачиж нэгдсэн хогын цэгт тээвэрлэн ажилласан.



14. Гамшигаас хамгаалах 2021-2024 оны төлөвлөгөөний дагуу аймгийн Онцгой байдлын хэлтсийн сургалт соён гэгээрүүлэх ажил хариуцсан мэргэжилтэнээр 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр 2 цагийн сургалт авч сургалтад тус хэлтсийн ажилтан алба хаагч хамрагдсан.

Тус бүртгэлийн хэлтэс нь үйл ажиллагаа явуулж байгаа барилга байгууламжийн галын



аюулгүй байдлыг ханган ажиллахдаа Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2021 оны А/07 дугаар тушаалаар батлагдсан “Архивын аюулгүй ажиллагааны журам”-ыг тус тус баримтлан ажиллаж учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор барилга байгууламжийн гадна тал болон өрөө тасалгааны цахилгаан, тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, цахилгаан дамжуулах утас, уртасгагч залгуурын аюулгүй байдлыг шалгаж галын хорны хэвийн ажиллагаа, гал түймэр гарсан үед гарах аврах зам, гарцын төлөвлөлтийн зургийг харагдахуйц газар байрлуулан байгууллага ажилтан алба хаагчийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Байгууллагын Гамшигаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөний төслийг аймгийн Онцгой байдлын газраас чиглэл авч дүгнэлт гаргуулан боловсруулан ажиллаж байна.



15. Монгол Улсын газраас хэрэгжүүлж буй Шинэ Хоршоо хөдөлгөөний хүрээнд Завхан аймгийн иргэд нэг дороос бүрэн мэдээлэл авах, хоршоогоо шууд байгуулах **нэг цэгийн үйлчилгээг** бүртгэлийн хэлтсийн байранд нээн ажиллуулж байна. Нэг цонхыг нээн ажиллуулсанаар 465 хоршоо шинээр байгуулагдаад байна.



16. Улиастай сумын Жинст багт 06 сарын 17-нд үүссэн үерийн нөхцөл байдалтай холбогдуулан үерт өртсөн 78 өрхийн иргэдтэй нэг бүрчлэн уулзаж бичиг баримтыг шалган бичиг баримт нь үерт урссан, норсон, ашиглах боломжгүй болсон иргэдийн баримт бичгийн



судалгааг гаргаж бичиг баримтжуулах ажлыг зохион байгуулж нийт 47 иргэний 781.000 төгрөгийн үнэ бүхий бичиг баримтыг олгох ажлийг аймгийн онцгой комисст уламжлан ажиллаад байна.



17. Онцгой байдлын 43-р ангитай хамтран гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх тархалтын сургалтыг зохион байгуулж, “Галын сайн дурын бүлгэм байгуулснаас гадна ажлын байрандаа галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулан ажилласан.



18. Улс тунхагласны баярын өдрийг тохиолдуулан Аймгийн засаг даргын тамгын газар, Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газартай хамтран шинээр 16 нас хүрч иргэний үнэмлэхээ авч байгаа хүүхдүүдээр иргэний андгай өргүүлэх ёслолыг 11 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаад байна.

Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан талаарх мэдээллийг иргэд олон нийтэд сурталчлах, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах мэдээ мэдээллийг байгууллагын фэйсбүүк фэйж хуудас болон вэб сайтад тухай бүрт нь байршуулан ажилласан.